



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын лаборатори 1-р сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/73/СТА-ТШЗ**

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг

түр орлон гүйцэтгэгч : Г.Заяа

Утас: 92038288

Цахим хаяг: zayag@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дагвасүрэн

Утас:99014227

Цахим хаяг: dagvasurenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	15
3.1 Ерөнхий зүйл.....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Материаллаг байдал	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	17
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

2022.02.22 № 1302/113.
танай _____ -ны № _____ -т

ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 1-Р
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.ЦЭРЭННАДМИД-д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын лаборатори 1-р сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын лаборатори 1-р сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

SORT_ID	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	72,044.90	87,039.40
60	БАРАА МАТЕРИАЛ	72,044.90	87,039.40
61	Түүхий эд материал	21,182.00	24,654.00
62	Тусгай зориулалттай материал	19,673.80	22,995.80
63	Эм боох материал	1,508.20	1,658.20
66	Хангамжийн материал	50,862.80	62,385.40
67	Бичиг хэргийн материал	1,508.80	1,508.80
68	Аж ахуйн материал	6,903.30	6,903.30
70	Түлш шатах тослох материал	2,400.00	-
71	Барилгын засварын материал	3,989.20	3,989.20
72	Хүнсний материал	158.40	10,979.80
73	Бусад хангамжийн материал	35,903.00	39,004.20
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,739,276.40	4,048,762.70
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,739,276.40	4,048,762.70
108	Биет хөрөнгө	3,044,886.40	3,322,997.70
109	Барилга, байгууламж	3,125,670.10	3,443,656.30
110	Хуримтлагдсан элэгдэл	(348,322.50)	(426,123.80)
111	Авто тээврийн хэрэгсэл	21,500.00	13,500.00
112	Хуримтлагдсан элэгдэл	(21,500.00)	-
113	Машин, тоног төхөөрөмж	433,808.10	338,600.90
114	Хуримтлагдсан элэгдэл	(344,801.00)	(254,558.30)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	201,666.10	234,526.80
116	Хуримтлагдсан элэгдэл	(108,526.10)	(119,316.50)
122	Бусад үндсэн хөрөнгө	42,847.50	42,847.50

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын лаборатори 1-р сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

123	Хуримтлагдсан элэгдэл	(25,860.10)	30,505.80
125	Номын фонд	68,404.40	80,370.70
126	Биет бус хөрөнгө	694,390.00	725,765.00
127	Програм хангамж	5,489.40	2,549.50
128	Хасагдуулга	3,754.40	(1,039.50)
129	Бусад биет бус хөрөнгө	692,655.00	724,255.00
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,811,321.30	4,135,802.20
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	3,811,321.30	4,135,802.20
215	Засгийн газрын хувь оролцоо	3,811,321.30	4,135,802.20
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	1,967,696.10	2,594,664.10
217	Өмч: -Төрийн өмч	1,967,696.10	2,594,664.10
223	Хуримтлагдсан үр дүн	883,055.90	588,942.70
224	Өмнөх үеийн үр дүн	883,055.90	891,429.80
225	Тайлант үеийн үр дүн	-	(302,487.10)
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	960,569.30	952,195.40
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	3,811,321.30	4,135,802.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

SORT_ID	ITEM_NAME	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,209,037.60	2,504,379.80
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	245,042.10	426,078.00
77	Нийтлэг татварын бус орлого	245,042.10	146,628.00
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	245,042.10	146,628.00
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	245,042.10	146,628.00
99	Тусламжийн орлого	-	279,450.00
100	Хандив тусламж /дотоод/	-	279,450.00
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	352,349.10	403,116.50

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын лаборатори 1-р сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

112	Улсын төвлөрсөн төсвөөс	313,706.90	329,437.60
113	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	313,706.90	329,437.60
119	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,611,646.40	1,675,185.30
122	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,642.20	76,678.90
127	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	38,642.20	76,678.90
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	2,201,359.00	2,201,359.00
148	УРСГАЛ ЗАРДАЛ	2,201,359.00	2,201,359.00
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,110,788.30	2,121,875.10
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,336,131.20	1,357,891.30
151	Цалин	815,100.30	840,140.70
152	Нэмэгдэл цалин	427,809.90	448,957.60
154	Урамшуулал	93,220.30	68,793.00
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	166,771.60	182,751.60
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	113,339.90	128,634.20
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	13,357.90	13,582.90
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	10,362.20	10,866.30
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	2,995.70	2,697.40
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	26,715.90	26,970.80
164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	309,506.60	330,037.60
165	Гэрэл цахилгааны зардал	13,194.70	15,804.40
166	Түлш, халаалтын зардал	295,355.60	312,856.00
167	Цэвэр, бохир усны зардал	956.30	1,377.20
170	Хангамж, бараа материалын зардал	34,583.10	9,078.00
171	Бичиг хэргийн материал	4,121.10	3,985.00
172	Тээвэр, шатахууны зардал	3,488.20	1,988.20

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын лаборатори 1-р сургуулийн 2021 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

173	Шуудан холбоо интернетийн төлбөр	855.00	1,000.00
174	Ном, хэвлэлийн зардал	515.50	215.00
175	Хог хаягдал устгах, цэвэрлэх	602.80	-
176	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	4,054.80	1,889.80
178	Бараа материал актасны зардал	20,945.70	-
181	Нормативт зардал	23,025.40	35,838.90
182	Эм	1,331.60	850.00
183	Хоол	20,359.00	33,131.40
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,331.60	1,857.50
185	Эд хогшил, урсгал засварын зардал	1,800.00	1,800.00
189	Урсгал засвар	1,800.00	1,800.00
190	Томилолт, зочны зардал	936.00	2,989.70
192	Дотоод томилолтын зардал	936.00	2,989.70
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,579.00	1,315.20
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,429.00	-
196	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	-	1,315.20
200	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	150.00	-
209	Бараа үйлчилгээний бусад зардал	236,455.50	200,172.80
211	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	8,461.30	13,068.30
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	227,994.20	187,104.50
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90,570.70	88,752.20
228	Бусад урсгал шилжүүлэг	65,239.20	87,376.30
232	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,716.50	53,407.20
235	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	37,522.70	31,969.10
236	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,000.00	2,000.00
237	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,331.50	1,375.90
240	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,331.50	1,375.90

268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	7,678.60	293,752.50
276	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	127,733.40	596,239.60
277	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	127,733.40	596,239.60
287	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(127,733.40)	(596,239.60)
288	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(120,054.90)	(302,487.10)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
0	ДАНС	511	51300	51210+51220	
2	2020 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	1,275,041.10	23,132.80	3,364,551.60	4,662,725.50
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,275,041.10	23,132.80	3,364,551.60	4,662,725.50
5	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн	-	-	-	-
6	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз	-	-	-	-
7	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
8	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	(218,771.50)	(218,771.50)
9	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,967,696.10	960,569.30	883,055.90	3,811,321.30
10	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,967,696.10	960,569.30	883,055.90	3,811,321.30
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	8,373.90	8,373.90
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,967,696.10	960,569.30	891,429.80	3,819,695.20
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(8.37)	-	(8,373.90)
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	626,968.00	-	-	626,968.00
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-

1 6	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
1 7	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	(302,487.10)	(302,487.10)
1 8	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,594,664.10	952,195.40	588,942.70	4,135,802.20

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

SORT_ID	ITEM_NAME	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,963,995.50	2,078,301.80
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,963,995.50	2,078,301.80
111	Улсын төвлөрсөн төсвөөс	313,706.90	329,437.60
112	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	313,706.90	329,437.60
118	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,611,646.40	1,675,185.30
121	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,642.20	73,678.90
126	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	38,642.20	73,678.90
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,958,372.30	2,036,596.80
148	УРСГАЛ ЗАРДАЛ	1,958,372.30	2,036,596.80
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,867,801.50	1,947,484.00
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,336,131.20	1,357,891.30
151	Үндсэн цалин	815,100.30	840,140.70
152	Нэмэгдэл	427,809.90	448,957.60
154	Үр дүнгийн урамшуулал	93,220.90	68,793.00
157	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	166,771.60	182,751.60
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	113,339.90	128,634.20
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	13,357.90	13,582.90
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	10,362.20	10,866.30
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	2,995.70	2,697.40
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	26,715.90	26,970.80
164	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	311,906.60	327,637.60

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын лаборатори 1-р сургуулийн 2021 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

165	Гэрэл цахилгааны зардал	13,194.70	15,804.00
166	Түлш, халаалтын зардал	297,755.60	310,456.00
167	Цэвэр, бохир усны зардал	956.30	1,377.20
170	Хангамж, бараа материалын зардал	14,244.20	9,078.00
171	Бичиг хэрэг	4,347.90	3,985.00
172	Тээвэр, шатахуун	3,488.20	1,988.20
173	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,100.00	1,000.00
174	Ном, хэвлэл	515.50	215.00
175	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	602.80	-
176	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,189.80	1,889.80
181	Нормативт зардал	24,771.70	47,630.30
182	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,331.60	1,000.00
183	Хоол, хүнс	19,997.90	43,952.80
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,442.20	2,677.50
185	Эд хогшил, урсгал засварын зардал	1,800.00	1,800.00
189	Урсгал засвар	1,800.00	1,800.00
190	Томилолт, зочны зардал	936.00	2,989.70
192	Дотоод албан томилолт	936.00	2,989.70
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,579.00	1,315.20
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,429.00	-
196	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,315.20
200	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150.00	-
208	Бараа үйлчилгээний бусад зардал	9,661.30	16,390.30
210	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	9,661.30	16,390.30
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90,570.70	89,112.80
225	Бусад урсгал шилжүүлэг	65,239.20	87,736.90
229	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	26,716.50	53,767.80

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын лаборатори 1-р сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

232	Хөдөө орон нутагт тогвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	37,522.70	31,969.10
233	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,000.00	2,000.00
234	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,331.50	1,375.90
237	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,331.50	1,375.90
250	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,623.30	41,705.00
251	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
261	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5,623.30	41,705.00
262	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,623.30	41,705.00
263	Дотоод эх үүсвэрээр	5,623.30	41,705.00
275	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,623.30	41,705.00
278	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(5,623.30)	(41,705.00)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

SORT_ID	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,004,622.90	2,003,247.00	1,375.90	99.93
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,004,622.90	2,003,247.00	1,375.90	99.93
4	Бараа, үйлчилгээний зардал	1,948,855.10	1,947,479.20	1,375.90	99.93
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,358,192.70	1,357,891.30	301.40	99.98
6	Үндсэн цалин	862,886.50	840,140.70	22,745.80	97.36
7	Нэмэгдэл	426,513.20	448,957.60	(22,444.40)	105.26
9	Урамшуулал	68,793.00	68,793.00	-	100.00
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	183,368.90	182,751.60	617.30	99.66
12	Тэтгэврийн даатгал	129,037.50	128,634.20	403.30	99.69

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын лаборатори 1-р сургуулийн 2021 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

13	Тэтгэмжийн даатгал	13,582.90	13,582.90	-	100.00
14	ҮОМШӨ ний даатгал	10,866.30	10,866.30	-	100.00
15	Ажилгүйдлийн даатгал	2,716.50	2,697.40	19.10	99.30
16	Эрүүл мэндийн даатгал	27,165.70	26,970.80	194.90	99.28
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	327,637.60	327,637.60	-	100.00
18	Гэрэл цахилгаан	15,804.40	15,804.40	-	100.00
19	Түлш, халаалт	310,456.00	310,456.00	-	100.00
20	Цэвэр, бохир ус	1,377.20	1,377.20	-	100.00
22	Хангамж, бараа материалын зардал	13,314.70	13,314.70	-	100.00
23	Бичиг хэрэг	3,374.70	3,374.70	-	100.00
24	Тээвэр (шатахуун)	1,988.20	1,988.20	-	100.00
25	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	1,000.00	1,000.00	-	100.00
26	Ном, хэвлэл	5,062.00	5,062.00	-	100.00
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	1,889.80	1,889.80	-	100.00
30	Нормативт зардал	47,639.30	47,639.30	-	100.00
31	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	1,000.00	1,000.00	-	100.00
32	Хоол, хүнс	43,952.80	43,952.80	-	100.00
33	Нормын хувцас зөөлөн эдлэл	2,677.50	2,677.50	-	100.00
34	Эд хогшил худалдан авах	1,800.00	1,800.00	-	100.00
38	Урсгал засвар	1,800.00	1,800.00	-	100.00
39	Томилолт, зочны зардал	3,446.90	2,989.70	457.20	86.73
41	Дотоод албан томилолт	3,446.90	2,989.70	457.20	86.73
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	1,315.20	1,315.20	-	100.00
45	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,315.20	1,315.20	-	100.00

Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын лаборатори 1-р сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

53	Бараа үйлчилгээний бусад зардал	12,148.80	12,148.80	-	100.00
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,148.80	12,148.80	-	100.00
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,767.80	55,767.80	-	100.00
70	Бусад урсгал шилжүүлэг	55,767.80	55,767.80	-	100.00
74	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	53,767.80	53,767.80	-	100.00
78	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	2,000.00	2,000.00	-	100.00
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,004,622.90	2,004,622.90	-	100.00
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,004,622.90	2,004,622.90	-	100.00
99	Улсын төсвөөс санхүүжих	329,437.60	329,437.60	-	100.00
101	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,675,185.30	1,675,185.30	-	100.00
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	98.00	99.00	(1.00)	101.02
134	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
135	Гүйцэтгэх ажилтан	67.00	68.00	(1.00)	101.49
136	Үйлчлэх ажилтан	30.00	30.00	-	100.00
138	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	1,050.00	1,066.00	(16.00)	101.50
139	Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид	1,050.00	1,066.00	(16.00)	101.50
140	Төрийн өмчит ЕБС	1,050.00	1,066.00	(16.00)	101.50
152	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	98.00	99.00	(1.00)	101.02
156	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч /ТҮБД/	68.00	69.00	(1.00)	101.47

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

SORT_ID	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	73,678.90	73,678.90	-	100.00
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	73,678.90	73,678.90	-	100.00
4	Бараа, үйлчилгээний зардал	41,709.80	41,709.80	-	100.00
22	Хангамж, бараа материалын зардал	610.30	610.30	-	100.00
23	Бичиг хэрэг	610.30	610.30	-	100.00
53	Бараа үйлчилгээний бусад зардал	41,099.50	41,099.50	-	100.00
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	41,099.50	41,099.50	-	100.00
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,969.10	31,969.10	-	100.00
70	Бусад урсгал шилжүүлэг	31,969.10	31,969.10	-	100.00
77	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	31,969.10	31,969.10	-	100.00
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	73,678.90	73,678.90	-	100.00
120	Нэмэлт санхүүжилтийн орлого	73,678.90	73,678.90	-	100.00
125	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	73,678.90	73,678.90	-	100.00
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	98.00	99.00	(1.00)	101.02
134	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
135	Гүйцэтгэх ажилтан	67.00	68.00	(1.00)	101.49
136	Үйлчлэх ажилтан	30.00	30.00	-	100.00
138	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	1,050.00	1,066.00	(16.00)	101.50
139	Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид	1,050.00	1,066.00	(16.00)	101.50
140	Төрийн өмчит ЕБС	1,050.00	1,066.00	(16.00)	101.50
148	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	-
152	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	98.00	99.00	(1.00)	101.02

156	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч /ТҮБД/	68.00	69.00	(1.00)	101.47
161	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/	30.00	30.00	-	100.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын лаборатори 1-р сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын ахлах аудитор Б.Дагвасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын лаборатори 1-р сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын лаборатори 1-р сургуулийн 2020-2021 оны хичээлийн жилд дараах зорилго болон зорилтыг тавин ажилласан байна.

ЗОРИЛГО:

Хүүхэд нэг бүрийн суралцаж, хөгжихөд нь тулгарч буй бэрхшээлийг арилгаж, амжилттай суралцахад нь бүх талын хамтын оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах.

ЗОРИЛТ:

Хүүхэд хөгжил, төлөвшлийн чиглэлээр:

- Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх сургуулийн бэлэн байдлыг хангах, цахим хичээлийн сан болон суралцагчийн бие даан суралцах үйлийг дэмжсэн даалгаврын сан бүрдүүлэх.

- Хүүхэд нэг бүрийн онцлог ялгаатай хэрэгцээнд тулгуурлаж сурах хөгжих үйлийг дэмжиж, хичээл сургалтын үйл ажиллагаанд тэдний оролцоог тэгш хангах, хамтран суралцах соёлыг төлөвшүүлэх.

- Дунд ахлах ангийн суралцагчид ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлээ зөв сонгоход нь дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх.

- “Хүүхдэд ээлтэй- Дотуур байр” хөтөлбөрийг хэрэгжүүлж, дотуур байрны хүүхдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах.

Багш хөгжлийн чиглэлээр:

- Цахим технологийг хичээл сургалтын үйл ажиллагааны үндсэн хэрэгсэл болгож багш нарыг мэргэжлийн бүлгээрээ ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлэх.

- Өдөр тутмын хичээл сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хандах, асуудлыг шийдвэрлэх эрэл хайгуул хийж учир шалтгааныг илрүүлэх, үнэлгээ дүгнэлт хийх үйлд чиглүүлэх.

- Элсэлтийн ерөнхий шалгалтын оноо болон чанарын үнэлгээ, бусад хөндлөнгийн шалгалтын дүн оноог өмнөх жилүүдээс ахиулах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Боловсролын яамнаас гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг дагаж мөрддөг бөгөөд болон дотоод хяналтыг хэрэгжүүлэхдээ 2020.10.19-ний өдрийн А/23 тоот тушаалаар Дотоод хяналт, үнэлгээний баг ажиллуулах тухай тушаал гаргаж журам, заавар зэргийг сайжруулан боловсруулж мөрдөн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тосонцэнгэл сумын ЕБ-ын лаборатори 1-р сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 2,504,379.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 50,087.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 40,070.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	72,044.86	87,039.42	14,994.56
Үндсэн хөрөнгө	3,739,276.4	4,048,762.74	309,486.34
Нийт хөрөнгө	3,811,321.26	4,135,802.16	324,480.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,811,321.26	4,135,802.16	324,480.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,811,321.26	4,135,802.16	324,480.9

Бараа материалын дансны үлдэгдэл 14,994.56 мянган төгрөгөөр өссөн нь сүүлийн 2-3 жилийн хугацаанд Ковид цар тахлын үед хүнсний материалын хомсдол үүсэх өндөр магадлалтай байгаа бөгөөд манай аймагт шүлхий өвчин ихээр дэгдсэнтэй холбоотойгоор мах, гурил, элсэн чихэр, будаа гэх мэт хүнсний зүйлийг нөөцөлсөн болон хүүхдийн орчинг бүрдүүлэхтэй холбоотой тохижилтын эд зүйлс худалдан авсан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь 2020-2021 онд манай сургуулийн түүхт 80 жилийн ойн хүрээнд Төгсөгчдийн холбоо ТББ-ын бүтээн байгуулалтын ажлууд өрнөж бетонон зам, талбай, төмөр хайс, хашаа, хаалга, сурагч баримал, хүүхдийн автобус, гацуур мод, бут гэх мэтийг хүлээлгэн өгч ажилласан, Завхан аймгийн ИТХ-ын тогтоолоор 2021 оны 08 сарын 17-ны өдрийн 40 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж үндсэн хөрөнгүүдийг акталж устгаж, данснаас хассан зэрэгтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 324,480.9 мянган төгрөгөөр өссөн нь дээрх үндсэн хөрөнгө, бараа материалын дансны өсөлттэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,004,622.9 мянган төгрөгөөр, 2,004,622.9 мянган төгрөгөөр нийт зарлагыг тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 329,437.6 мянган төгрөгийн, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 1,675,185.3 мянган төгрөгийн, нийт 2,004,622.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 2,003,244.0 мянган төгрөгийг зарцуулж, 1,375.86 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Төсвийн гүйцэтгэлээс хянахад цалин хөлс, НДШ-ээс 918.61 мянган төгрөгийг хэмнэсэн, дотоод албан томилолтын зардлаас 457.25 мянган төгрөг хэмнэсэн харагдаж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд багш нарт олгох нэг удаагийн тэтгэмжээр 31,969.12 мянган төгрөг, Боловсрол соёлын газраас 610.3 мянган төгрөг, Боловсролын мэдээллийн технологийн төвийн “Контент боловсруулах лаборатори байгуулах 19,000.00 мянган төгрөг, БШУЯ-ны Боловсролын чанарын шинэчлэл төслийн “Би чадна” төслийн 8,000.00 мянган төгрөг, Насан туршийн боловсролын нэгжийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургалтын орчин -сэргээн засалтын нөхцлийг сайжруулах” танхим тохижуулах төслийн 12,750.00 төгрөг, сум хөгжүүлэх сангийн Багшийн хөгжлийг дэмжихэд 1,000.00 мянган төгрөг, Уур амьсгалын өөрчлөлтэй холбоотой Завхан аймгийн ГБХЗХГазраас газар зүйн кабенетад хэрэгжсэн төслийн сургалтын 349.5 мянган төгрөгийн нийт 73,678.92 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг бүрдүүлэн зориулалтын дагуу бүрэн зарцуулсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

3.8 Аудитын гол асуудал

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43-р тогтоолыг зөрчиж 1,320.0 мянган төгрөгийн принтер худалдан авсан, багш нарт биеийн тамирын хувцас 550.0 мянган төгрөгөөр худалдан авч өгсөн, БШУЯ-аас үнэ төлбөргүй нийлүүлсэн 11,655.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авснаар тайлагнасан зэрэг зөрчил дутагдал илэрсэн

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Санхүүгийн тайлан болон төсвийн зарцуулалт нь бусад холбогдох хууль тогтоомж, журам зааварын дагуу байлаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 9 мэдээллийг хугацаа хожимдуулж, 140 мэдээллийг хугацаанд нь нийт 149 мэдээллийг бүрэн оруулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгснөөс 50 хувийг хэрэгжүүлэн ажилласан.

- ✓ Бараа, материалын тайлан хангалтгүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу, бараа материалыг зарцуулахдаа шаардах хуудас болон зарлагын баримтыг бүрдүүлдэггүй зөрчлийг арилган, няравын тайланг үнэн зөв бэлтгэсэн байна.
- ✓ Багш нарын ашиглаж байсан принтерүүд актлагдаж, дахин 2-3 принтер хэрэгцээ гарсан тул принтер худалдан авч өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Си-Ти-Эс ХХК-аас нийлүүлэгдсэн 1,650.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн программыг бүртгэлд тусгасан боловч ашиглаагүй, программын үр дүнг гаргаагүй зөрчлийг дараагийн аудитаар шалгана.

4. Аудитын илрүүлэлт

4.1 Залруулсан алдаа

Дотуур байрны хоолноос 2,488.5 мянган төгрөгийг үдийн цайнд гүйлгэн тайлагнасан, БШУЯ-аас нийлүүлсэн 11,655.0 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авснаар тайлагнасан алдааг залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Сургуулийн багш нарт биеийн тамирын хувцас 550.0 мянган төгрөгөөр худалдан авч өгснийг буцаан төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

4.3 Албан шаардлага хүргүүлээгүй

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал*

1.1. Илрүүлэлт:

Засгийн газрын 2021 он "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43-р тогтоолыг зөрчиж 1,320.0 мянган төгрөгийн принтер худалдан авсан.

1.2. Өгсөн зөвлөмж:

Засгийн газраас тухайн жилийн төлөвлөлт болон төсвийн зардалтай холбогдон гаргасан тогтоолыг дагаж мөрдөх, төсвийг зориулалт бусаар зарцуулахгүй байх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1.	Тосонцэнгэл сумын ЕБ-ын лаборатори 1-р сургууль	4	16.0	2	14.1	1	0.55			1	1.32